ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

e mongolia 4.0

# ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОПЕРАТОРЫН СИСТЕМ 3.0

Төрийн үйлчилгээний оператор ажилтанд зориулав



Улаанбаатар хот 2025 он

# Агуулга

01 **Нэвтрэх хэсэг**
02 **Нэмэлт цэсүүд**
03 **Хянах самбар**
04 **Мэдээ, зар**
05 **Тикет**
06 **Хүсэлтүүд**
07 **Хүсэлт үүсгэх**
08 **Төлбөр төлөлт**
09 **Тайлан**
10 **Бусад ажил**

## 1.1 Нэвтрэх Системд нэвтрэх заавар нэг

• И-мэйл болон нууц үг хэсэгт үүсгэсэн бүртгэлтэй и-мэйл хаяг, нууц үгийг бичиж нэвтрэх товчийг дарна. Зураг 1.1




**ЗУРАГ 1.1** И-мэйл, нууц үг ашиглан системд нэвтрэх

• Хоёр давхар баталгаажуулалтыг Утас эсвэл И-мэйлээр хийнэ. Зураг 1.1.1




**ЗУРАГ 1.1.1** Хоёр давхар баталгаажуулалт

• Утас гэж сонгосон тохиолдолд та утасны дугаараа оруулж, тус дугаараасаа үүссэн 6 оронтой тоог илгээж, шалгах дарснаар амжилттай нэвтэрнэ. Зураг 1.1.2




**ЗУРАГ 1.1.2** Утасны дугаараар давхар баталгаажуулалт хийх

• И-мэйл гэж сонгосон тохиолдолд таны мэйлд очсон 6 оронтой тоог оруулж, шалгах дарснаар та системд амжилттай нэвтэрнэ. Зураг 1.1.3




**ЗУРАГ 1.1.3** И-мэйлээр давхар баталгаажуулалт хийх

## 1.2 Нэвтрэх Системд нэвтрэх заавар хоёр

• Операторын системд e-mongolia системийн QR нэвтрэлт ашиглан нэвтрэх боломжтой. Оператор системийн нэвтрэх цонхонд харагдаж буй QR нэвтрэлт гэсэн сонголтыг сонгож гарч ирсэн QR-ыг e-mongolia апп дээрх QR уншигчаар уншуулж нэвтэрнэ.
*/ Заавал апп дээр өөрийн эрхээр нэвтэрсэн байх шаардлагатай /* Зураг 1.2




ЗУРАГ 1.2 e-mongolia системийн QR нэвтрэлт ашиглан нэвтрэх

• Намайг сана дарснаар та компьютер дээрээ бүртгэлтэй и-мэйл хаягийг санулах боломжтой.
• Хэрэв та нэвтрэх нууц үгээ мартсан тохиолдолд Нууц үг сэргээх хэсгийг товшиж нууц үг сэргээх хүсэлт илгээснээр таны бүртгэлтэй и-мэйл хаягт холбоос ирнэ. Зураг 1.2.1




ЗУРАГ 1.2.1 Нууц үг сэргээх

• Оператор системд нэвтрэхдээ Салбар сонголтоос өөрийн ажиллаж буй Төрийн үйлчилгээний цэгийг заавал сонгож, үргэлжлүүлэх дарах шаардлагатай. Зураг 1.3




**ЗУРАГ 1.3** Салбар сонголт

## A Хувийн мэдээлэл

Тухайн нэвтэрч орсон хэрэглэгчийн хувийн мэдээлэл байрлана.

• Оператор системд нэвтрэхдээ Салбар сонголтоос өөрийн ажиллаж буй Төрийн үйлчилгээний цэгийг заавал сонгож, үргэлжлүүлэх дарах шаардлагатай. Зураг 1.4




**ЗУРАГ 1.4** Хувийн мэдээлэл засах

## B Нууц үг

• Хувийн мэдээлэл шинэчлэх хэсэгт хэрэглэгч өөрийн одоо байгаа нэвтрэх нууц үгээ солих боломжтой. Нууц үг нь өгөгдсөн шаардлагыг хангасан тохиолдолд солигдохыг анхаарна уу. Зураг 1.5




**ЗУРАГ 1.5** Нууц үг солих

## C Системээс гарах

• Систем нэвтрэлтийн хугацаа нь 4 цаг бөгөөд тус хугацааны дараа гарах үйлдэл хийгдэхгүйгээр систем өөрөө гарахыг анхаарна уу.

- Тус цэсүүд нь Хувийн мэдээллийн хажууд header хэсэгт байрлах бөгөөд операторт хэрэгцээт нэмэлт цэсүүд юм. Зураг 2.1




ЗУРАГ 2.1 Нэмэлт цэсүүд

## ЧАТ
## NOTIFICATION БУЮУ МЭДЭГДЭЛ
## ХАЯГ БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ
## ТИКЕТ БҮРТГЭХ, БУСАД АЖИЛ БҮРТГЭХ



## 2.1.1 Чат

- Чат нь оператор систем хэрэглэгчид хоорондоо харилцах суваг юм. Зураг 2.1.1

Дундын групп чат үүсгэх    Нэг нэг чатлах    Зураг илгээх    Файл солилцох




**ЗУРАГ 2.1.1** Чат

## 2.1.2 Notification буюу Мэдэгдэл

- Чат нь оператор систем хэрэглэгчид хоорондоо харилцах суваг юм. Зураг 2.1.1

**A** **Ерөнхий мэдэгдэл нь тус оператор хэрэглэгчийн үүсгэсэн үйлчилгээний явцын мэдээлэл, мөн Мэдээ, зарын мэдэгдлийг ирнэ.**

**B** **Тикет мэдэгдэл нь тус оператор хэрэглэгчийн бүртгэсэн Тикет /*Алдаа* /-ны явцын талаарх мэдээлэл ирнэ.**




**ЗУРАГ 2.1.2** Ерөнхий мэдэгдэл болон Тикет мэдэгдэл

## 2.1.3 Хаяг байршлын мэдээлэл

• Хаяг байршлын мэдээллээс оператор өөрт ойрхон бусад Төрийн үйлчилгээний цэгийн Хаяг байршлын дэлгэрэнгүй мэдээлэл, Цагийн хуваарийн мэдээлэл харах боломжтой. Зураг 2.3




**ЗУРАГ 2.1.3** Хаяг байршлын мэдээлэл

## 2.1.4 Тикет бүртгэх

• Оператор хэрэглэгч систем дээр ажиллаж байх үед тулгарсан алдааны мэдээлэл болон асуудлыг бүртгэнэ Зураг 2.1.4

Тикет бүртгэхдээ:

**A** **Чухлын зэргийг бага, дунд, их, чухал-аас сонгож өгнө.**

**B** **Агуулга хэсэг нь алдааны дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ. Тус алдаа нь үйлчилгээ тохиолдолд үйлчилгээний хүсэлтийн дугаар эсвэл регистр дугаар заавал оруулах шаардлагатай. Хэрэв шаардлага хангаагүй бол тикет шийдвэрлэгдэхгүй болно.**

**C** **Алдааны зургийг хавсаргаж өгнө.**




**ЗУРАГ 2.1.4** Тикет бүртгэх

## 2.1.5 Бусад ажил бүртгэх

- Оператор нь operator.e-mongolia.mn системээр үйлчилгээ үзүүлэхээс гадна e-business.mn, e-mongolia.mn, аппликейшн ашиглаж иргэн, аж ахуй нэгжид үйлчилгээ үзүүлж, тоон гарын үсэг олгож, бусад нэмэлт заавар зөвлөгөө иргэнд өгдөг.

Энэ цэсэд оператор бусад нэмэлт ажлаа бүртгэх цэс юм. Зураг 2.1.5

Үйл ажиллагаа бүртгэхдээ:

**A** **Үйл ажиллагааны төрөл сонгох / *өгөгдсөн төрлөөс сонгоно* /**

**B** **Бусад ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бичих**

**C** **Нэмэлт ажил авсан иргэний регистр дугаар оруулах**




**ЗУРАГ 2.1.5** Бусад ажил бүртгэх

Хянах самбар цэсэд тухайн Операторын үзүүлсэн үйлчилгээнүүдийг дараах байдлаар ангилан харуулах боломжтой.

## 3.1

• Үйлчилгээ үзүүлсэн нийт тоо, Лавлагаа, Нэг шатлалт, Хоёр шатлалт, Олон шатлалт, Нэмэлт ажлын тоо тус бүрээр, мөн График болон Хүснэгт хэлбэрээр харах боломжтой. Хүснэгтээр харах тохиолдолд диаграммаас нэг сарыг заавал сонгоно. Хугацааны хувьд Өнөөдөр, 7 хоногоор, Сараар, Жилээр фильтердэж хайж мэдээллээ шинэчлэх боломжтой. Зураг 3.1




**ЗУРАГ 3.1** Бусад ажил бүртгэх

## 3.2

• 3.2.Сэтгэл ханамжийн үнэлгээ нь 7 төрлөөр үнэлэгдэж байгаа. Зураг 3.2




| | |
|---|---|
| Улаан | Үнэхээр хэцүү (1) |
| Ягаан | Хэцүү (2) |
| Улбар шар | Хэцүүвтэр (3) |
| Шаргал | Мэдэхгүй (4) |
| Шар | Дундаж (5) |
| Ногоон | Хялбар (6) |
| Неон ногоон | Үнэхээр хялбар (7) |

**ЗУРАГ 3.2** Бусад ажил бүртгэх

## 3.3

• Үйлчлүүлэгчийн төрөл нь нийт үйлчилгээ авагчийг Иргэн, Хуулийн этгээд эсэхийг тодорхойлсон тоон мэдээллийг харуулсан chart юм. Зураг 3.3




**ЗУРАГ 3.3** Үйлчлүүлэгчийн төрөл

## 3.4

• Хандалт ихтэй үйлчилгээ нь сонгосон салбар, хугацааны дагуу хамгийн эрэлттэй байсан 10 үйлчилгээг харуулах. Зураг 3.4




**ЗУРАГ 3.4** Хандалт ихтэй үйлчилгээ

## 3.5

• Бусад ажлын бүртгэлийн тоон мэдээлэл. Зураг 3.5




**ЗУРАГ 3.5** Бусад ажлын бүртгэл

- Операторын супер админаас оператор систем хэрэглэгчдэд шаардлагатай мэдээ мэдээлэл, зарыг хүргэнэ.

Мэдээ мэдээлэл:

Тус бүртгэсэн мэдээнд оператор комментоор санал солилцох, нийтэлсэн мэдээнд зүрх дарах боломжтой. Зураг 4.1




ЗУРАГ 4.1 Мэдээ мэдээлэл

- Цаг үеийн мэдээлэл / *зарын чанартай* /:

Цаг үеийн мэдээлэл нь систем дээр олон цагаар гарах доголдол үүсэж магадгүй талаарх мэдээлэл, шинээр нэвтэрсэн үйлчилгээний мэдээлэл, үйлчилгээний сайжруулалт зэрэг мэдээллийг хүргэнэ. Зураг 4.2




ЗУРАГ 4.2 Цаг үеийн мэдээлэл



• Операторын өөрийн бүртгэсэн Алдаа болон явцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус цэсээс харна. Зураг 5.1



Тикетийн дугаар: Тикетийн дугаар
Чухлын зэрэг:
Төлөв:
Хэлтэс:
Хайх
Филтер цэвэрлэх

| № | Дугаар | Төлөв | Чухлын зэрэг | Бүртгэсэн огноо | Шинэчилсэн огноо | Бүртгэсэн ажилтан | Үйлдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | T250129000001 | Хүлээн авсан | Бага | 2025-01-29 11:23:44 | 2025-01-29 16:22:01 | Баянжаргал | |
| 2 | T250128000011 | Ноорог | Бага | 2025-01-28 19:11:28 | 2025-01-29 16:22:01 | Даваасамбуу | |
| 3 | T250128000010 | Ноорог | Бага | 2025-01-28 19:10:52 | 2025-01-29 16:22:01 | Даваасамбуу | |
| 4 | T250128000009 | Ноорог | Бага | 2025-01-28 18:56:14 | 2025-01-29 16:22:01 | Даваасамбуу | |
| 5 | T250128000006 | Ноорог | Дунд | 2025-01-28 16:08:06 | 2025-01-29 16:22:01 | Алтанбек | |
| 6 | T250128000005 | Ноорог | Дунд | 2025-01-28 16:07:35 | 2025-01-29 16:22:01 | Алтанбек | |
| 7 | T250128000004 | Ноорог | Дунд | 2025-01-28 15:22:16 | 2025-01-29 16:22:01 | Мөнхгэрэл | |
| 8 | T250128000003 | Ноорог | Дунд | 2025-01-28 14:47:30 | 2025-01-29 16:22:01 | Алтанбек | |

**ЗУРАГ 5.1** Тикет жагсаалт

## Хайлт:

- **Алдаа бүртгэхэд үүссэн Тикетийн дугаар**
- **Тикетийн чухлын зэргээр / *бага, дунд, их, чухал /***
- **Явцын төлөвөөр / *ноорог, шинэ, шууд шийдвэрлэсэн, хуваарилсан, хүлээн авсан, ажилтан шийдвэрлэсэн, хаагдсан, ажилтанд буцаасан, цуцлагдсан, хүлээгдэж байгаа /***
- **Фильтер цэвэрлэх / *Хайлтын утгыг цэвэрлэх /***

• Бүртгэсэн тикетийн явцын мэдээллийг Үйлдэл дээр дарж дэлгэрэнгүй харах боломжтой. Зураг 5.1.1



Тикетийн дугаар
T250129000001
Бүртгэсэн ажилтан
Б. Баянжаргал
Чухлын зэрэг
Бага
Бүртгэсэн огноо
2025-01-29 11:23:44
Тикет групп
-
Агуулга
system dr alfaa garsan
Хавсралт файл
827991bb-192c-4f2e-a748-f8243e2d2984.png
Шийдвэрлэлтийн явц
Шинээр бүртгэсэн 2025-01-29 19:23:44
Шийдвэрлэж байгаа 2025-01-29 19:25:05
Шийдвэрлэсэн

**ЗУРАГ 5.1.1** Тикет дэлгэрэнгүй

## 6.1 Хүсэлтийн жагсаалт

- Хүсэлтүүд - Миний хүсэлтүүд цэсээс оператор өөрийн үүсгэсэн үйлчилгээнээс шүүлт хийх боломжтой. Зураг 6.1.1




**ЗУРАГ 6.1.1** Миний хүсэлтүүд

- Хүсэлтүүд - Нийт цэснээс бусад хамаарах салбарын операторын үүсгэсэн 2 шатлалт үйлчилгээний хүсэлтүүд харагдаж иргэнд үйлчилгээний төлөв, процессыг мэдээллэх боломжтой. Зураг 6.1.2




**ЗУРАГ 6.1.2** Нийт хүсэлтүүд

## 6.2 Хайлт

- **Регистрийн дугаар, Хүсэлтийн дугаараар, утасны дугаараар хайлт хийх;**
- **Төлөв сонгох / Бүх төлөвүүдээс сонголт хийх /**
- **Шатлал сонгох / Нэг шатлалт, хоёр шатлалт /**
- **Дэлгэрэнгүй хайлт хийх (Үйлчилгээ тус бүрээр, Салбар, нэгж,)**
- **Цэвэрлэх / Хайлтын утгыг цэвэрлэх /** Зураг 6.2




**ЗУРАГ 6.2** Нийт хүсэлтүүд

## 6.3 Төлөв

• Операторын хүсэлтүүдийн жагсаалтыг явцын төлөвийг дараах байдлаар харуулна. Хүсэлтийн төлөвийг доорх хүснэгтэд харуулав.

| Хүсэлтийн ангилал | Төлөв | Тайлбар |
|---|---|---|
| Нээлттэй | *Шинэ* | ***• Оператор хүсэлтийг шинээр үүсгэсэн, амжилттай үүсээгүй төлөв*** |
| | *Илгээсэн* | ***• Олон шатлалт үйлчилгээний хувьд хүсэлтийг үүсгээд холбогдох байгууллагад илгээсэн төлөв<br>• Нэг шатлалт үйлчилгээний хувьд (торгууль, татвар, замын хураамж төлөлт г.м) төлбөр нь амжилттай төлөгдсөн төлөв*** |
| | *Боловсруулж байгаа* | ***• Операторын илгээсэн хүсэлтийг холбогдох байгууллага хүлээн авч шийдвэрлэхийн тулд дотоод боловсруулалт хийж байгаа төлөв*** |
| | *Засварт буцаасан* | ***• Операторын илгээсэн хүсэлтийг хүлээн авч засварт буцаасан төлөв*** |
| | *Нэмэлт материал шаардсан* | ***• Тухайн үйлчилгээг шийдвэрлэхэд нэмэлт материал шаардлагатай болсон эсвэл материал дутуу байх төлөв*** |
| | *Баталсан* | ***• Дараа төлбөрт олон шатлалт үйлчилгээний хүсэлтийг хүлээж аваад төлбөр хүлээгдэж буй төлөв*** |
| Шийдвэрлэсэн | *Зөвшөөрсөн* | ***• Лавлагаа, тодорхойлолтын хувьд амжилттай лавлагаа үүссэн төлөв<br>• Олон шатлалт үйлчилгээний хувьд холбогдох байгууллага шийдвэрлэж системд үр дүн нь ирсэн төлөв*** |
| | *Татгалзсан* | ***• Холбогдох байгууллагаас үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй төлөв*** |
| | *Олгосон* | ***• Зөвшөөрсөн төлөвтэй үйлчилгээний хүсэлтийг хүсэлт гаргагчид олгосон төлөв*** |
| | *Амжилтгүй* | ***• Системийн техникийн саатлаас хамааран илгээх явцад тасалдал үүссэн төлөв*** |

Операторын үйлчилгээний хүсэлтийн тайлбар

## 6.4 Хүсэлтийн дэлгэрэнгүй

• “Үйлдэл” гэсэн талбарт хамаарах тэмдэглэгээ дээр “Дэлгэрэнгүй” гэх илэрч харагдах бөгөөд үүн дээр хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл дараах байдлаар харагдана. Үйлчилгээ тус бүрийн хэрэгжүүлэх алхмаас хамаарч дэлгэцэд харагдах мэдээлэл өөрчлөгдөхийг анхаарна уу. Лавлагаа үйлчилгээ нь төлбөргүй тохиолдолд зөвхөн хүсэлтийн мэдүүлэг харна. Зураг 6.4.1




**ЗУРАГ 6.4.1** Хүсэлтийн дэлгэрэнгүй

• Төлбөртэй лавлагаа үйлчилгээ тохиолдолд Лавлагаа дахин гаргах, Лавлагааг дахин авах хэвлэх боломжтой. Зураг 6.4.2




**ЗУРАГ 6.4.2** Хүсэлтийн дэлгэрэнгүй

- **“Төлбөр” хэсгээс тухайн үйлчилгээний төлбөр амжилттай төлөгдсөн эсэх талаарх мэдээлэл, PDF харах хэсэгт дарж төлбөрийн баримтыг харах боломжтой.**
- **Хэрэв данснаас төлбөр хасагдаад үйлчилгээний төлөв “Шинэ” төлөвтэй үйлчилгээний хүсэлтийн дугаар үүсээгүй тохиолдолд оператор ‘Төлбөр баталгаажуулах’ дарж лавлагааг амжилттай үүсгэх боломжтой.**
- **“Хүсэлтийн мэдүүлэг” дээр дарж хүсэлт гаргагчид “Төрийн үйлчилгээний хүсэлтийн мэдүүлэг”-ийг хэвлэж өгөх боломжтой.**
- **Хоёр шатлалт үйлчилгээний хувьд Хүсэлтийн мэдүүлэг, буцах хуудсыг үйлчилгээний хүсэлтийг хүлээн авсны нотлох баримт болгон хэвлэж өгөх ёстой анхаарна уу.**

Хүсэлтийн мэдүүлгийн хуудас нь :

- Мэдүүлгийн мэдээлэл
- Хүсэлт гаргагчийн мэдээлэл
- Өргөдлийн мэдээлэл
- Хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн мэдээлэл
- Төлбөрийн  мэдээлэл
- Шийдвэрлэлтийн явцын мэдээлэл зэргийг агуулна



- Операторын хүлээн авсан үйлчилгээний хүсэлтийг гүйцэтгэх үндсэн ажиллах цэс юм.

## 7.1 Шаардлагатай программууд

- **Esign цахим гарын үсгийн программ**
  / *https://www.esign.gov.mn/esign-client-program* / **линкээр орж татах**
- **Иргэний үнэмлэх уншигчийн мэдээлэл дамжуулах программ**
  / *https://drive.google.com/drive/my-drive* / **татаж авч уншуулах**
- **Пос машинд төлбөрийн мэдээлэл дамжуулах программ**
  / *pos config зааврын дагуу тохируулах* /

## 7.2 Үйлчилгээний жагсаалт

- •Үйлчилгээг үйлчилгээний нэрээр болон Чиглэл, Үйлчилгээ үзүүлэгч байгууллага, Үйлчилгээний төрлөөр сонгон хайлт хийх боломжтой. Зураг 7.2.1




**ЗУРАГ 7.2.1** Үйлчилгээний жагсаалт

## 7.3 Үйлчилгээ сагслах

• Нийт үйлчилгээнээс төлбөрийн хувьд дараа төлбөрт болон төлбөргүй лавлагаа үйлчилгээг сагсалж, нэг баталгаажуулалтаар олон үйлчилгээг авах боломжтой. Зураг 7.3.1




**ЗУРАГ 7.3.1** Сагслагдсан үйлчилгээ

Тус тэмдэглэгээтэй үйлчилгээ нь сагслах боломжгүй үйлчилгээ тул нэгээр авна.

Тус тэмдэглэгээтэй үйлчилгээ нь сагсалж авах боломжтой.

Сагслах боломжгүй үйлчилгээг авахад шууд үйлчилгээ дээр дарж, цааш Үргэлжлүүлэх дарна.

Сагслах боломжтой үйлчилгээг дангаар нь авахад тус тэмдэгт дээр дарж үйлчилгээний мэдээлэлтэй танилцаж ***Үргэлжлүүлэх*** дарна.

Тус тэмдэглэгээтэй үйлчилгээ нь сагсанд хийгдэнэ.

Тус сагсалсан үйлчилгээнээс хасах, буцаж нэмэх боломжтой.

## 7.4 Иргэн / Байгууллага баталгаажуулах

Хүсэлт гаргагчийг тодорхойлох:

**I** **Хүсэлт гаргагчийн төрөл сонгох**
**II** **Хүсэлт гаргагчийг баталгаажуулах төрөл сонгох**
**III** **Хүсэлт гаргаж буй төрөл сонгох**
**IV** **Хүсэлт гаргагчийг таниулах**
**V** **Оператор өөрийн тоон гарын үсгээ зурж баталгаажуулах**

Хүсэлт гаргагчийн төрөл, баталгаажуулах төрөл, хэлбэр:

| Хүсэлт гаргагчийн төрөл | Хүсэлт гаргагчийг баталгаажуулах төрөл | Хүсэлт гаргаж буй хэлбэр |
|---|---|---|
| • ***МУ-ын иргэн***<br>• ***Аж ахуйн нэгж, байгууллага***<br>• ***Гадаадын иргэн*** | • ***Иргэний цахим үнэмлэх***<br>• ***Нэг удаагийн код-оор баталгаажуулах***<br>• ***Хурууны хээ*** | • ***Өөрийн биеэр хүсэлт гаргаж буй***<br>• ***Хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан хүсэлт гаргаж буй*** |

## 7.4.1 Хүсэлт гаргагчийн төрөл

МУ-ын иргэн тохиолдолд:

• Иргэнд зориулсан үйлчилгээ тохиолдолд хүсэлт гаргагчийн төрөл МУ-ын иргэн сонголт default байна. Зураг 7.4.1

• Хүсэлт гаргагчийг баталгаажуулах төрөл Нэг удаагийн код-оор баталгаажуулах тохиолдолд Хүсэлт гаргагчийн регистр дугаарыг гараас бичиж, утасны дугаар руу код илгээж баталгаажуулна. Хэрэв хэрэглэгч өөрийн нэр дээрх өөр бүртгэлтэй дугаар дээр код авах бол доор сонголтоор сонгож, утасны дугаар оруулж код авна.

• Хүсэлт гаргагчийг баталгаажуулах төрөл Иргэний цахим үнэмлэх тохиолдолд Иргэний үнэмлэх унших төхөөрөмжийг ачаалуулж, иргэний үнэмлэх уншуулна.
• Хүсэлт гаргагчийг баталгаажуулах төрөл Хурууны хээ тохиолдолд Хүсэлт гаргагчийн регистр дугаарыг гараас бичиж, хурууны хээ уншуулж баталгаажуулна.
• Хүсэлт гаргаж буй иргэн нь өөрийн биеэр болон хууль ёсны төлөөлөгчөөр үйлчилгээг авах эрхтэй.

• Хэрэв хүсэлт гаргагч нь хууль ёсны төлөөлөгчөөр хүсэлт гаргах бол тухайн төлөөлж ирсэн хүний иргэний үнэмлэхийг уншуулж баталгаажуулна. Үүний өмнө иргэний үнэмлэх уншигч программыг урьдчилан ажиллуулан байх ёстой.

• Тухайн хүсэлтийг баталгаажуулахдаа оператор ажилтан өөрийн тоон гарын үсгээр өөрийгөө баталгаажуулах бөгөөд үүний тулд E-Sign программыг урьдчилан татаж суулгасан байх ёстой. Мөн тоон гарын үсгийн токен төхөөрөмжөө холбосон байна.

• Гарч ирсэн цонхонд өөрийн 8 оронтой пин кодыг хийж "Үргэлжлүүлэх" дарна.

• Тоон гарын үсэг амжилттай уншсаны дараа "Ок" товч дээр дарж үргэлжлүүлнэ.




**ЗУРАГ 7.4..1** МУ-ын иргэн баталгаажуулалт

## 7.4.2 Хүсэлт гаргагчийн төрөл Аж ахуй нэгж

Байгууллага тохиолдолд:

• ААН-д зориулсан үйлчилгээ тохиолдолд хүсэлт гаргагчийн төрөл Аж ахуй нэгж, байгууллага сонголт default байна. Зураг 7.4.2

• Хүсэлт гаргагчийн төрөл Аж ахуй нэгж, байгууллага тохиолдолд баталгаажуулах төрөл Байгууллагын тоон гарын үсэг байна

**I** **Байгууллагын регистр дугаар**

**II** **Тоон гарын эзэмшигчийн регистр дугаар бөглөх шаардлагатай**

**III** **Эхлээд байгууллагын тоон гарын үсгийг баталгаажуулна**

**IV** **Дараа нь оператор өөрийн тоон гарын үсгийг баталгаажуулна**




**ЗУРАГ 7.4.2** ААН баталгаажуулалт

## 7.4.3. Амжилттай үүссэн хүсэлт

Илгээгдсэн тохиолдолд:

• •Үйлчилгээний хүсэлт амжилттай илгээгдсэн, лавлагаа тодорхойлолт амжилттай үүссэн тохиолдолд "Үнэлгээ" өгөх цонх гарч ирнэ. Үнэлгээг тус үйлчилгээг авсан иргэн өгөхийг анхаарна уу. Зураг 7.4.3

• •Лавлагаа тодорхойлолт амжилттай үүссэний дараагаар үр дүнг мэйлээр илгээх, иргэнд хэвлэж өгөх боломжтой.




**ЗУРАГ 7.4.3** Үнэлгээ өгөх

# Төлбөр төлөлт

- Операторын үзүүлсэн төлбөртэй үйлчилгээний жагсаалт харуулах цэс юм. Зураг 8.1

Хайлт:

- **Төлбөрийн дугаар**
- **Төлөгчийн регистр**
- **Төлбөрийн хэлбэр**
- **Төлөв**
- **Огноо**
- **Үйлчилгээ үзүүлэгч байгууллага**
- **Үйлчилгээний нэр**




**ЗУРАГ 8.1** Төлбөр төлөлт

- "Үйлдэл" гэсэн талбарт хамаарах тэмдэглэгээ дээр "Дэлгэрэнгүй" гэх илэрч харагдах бөгөөд үүн дээр Төлбөр, төлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл дараах байдлаар харагдана. Зураг 8.1.1




**ЗУРАГ 8.1.1** Төлбөрийн дэлгэрэнгүй

Операторын үзүүлсэн үйлчилгээний нийт тайлан, үнэлгээний тайланг татах боломжтой цэс юм.

- **Салбараар үзүүлэлтийн тайлан.** Зураг 9.1




ЗУРАГ 9.1

- **Салбараар үзүүлэлтийн тайлан.** Зураг 9.2




ЗУРАГ 9.2

- **Ажилтны үнэлгээний тайлан .** Зураг 9.3




| Салбарын нэр | Нэвтрэх нэр | Үнэлгээ | Нийт үнэлгээ |
|---|---|---|---|
| Багахангай 2-р хорооны байран дахь "ХУРДА... | batjargal.u@bagakhangai.ub.gov.mn | Үнэлгээ: 3 / Нийт: 1 | 1 |
| Баянзүрх дүүргэт байрлах Төр захиргааны 2-... | altangoo@khurdan.gov.mn | Үнэлгээ: 3 / Нийт: 4 | 4 |
| Багануур 4-р хорооны байран дахь "ХУРДАН... | baganuur4@ulaanbaatar.mn | Үнэлгээ: 3 / Нийт: 5 | 5 |
| ЧД 21-р хорооны байран дахь "ХУРДАН" цэг | lkh.bolortuya@khurdan.gov.mn | Үнэлгээ: 3 / Нийт: 1 | 1 |
| "Жанжин клуб" соёлын ордон дахь "ХУРДАН... | enkhtuul@khurdan.gov.mn | Үнэлгээ: 3 / Нийт: 12 | 12 |

**ЗУРАГ 9.3**

- **Бусад ажлын тайлан.** Зураг 9.4




| Ажилтан | Салбар | Төрөл | Тоо |
|---|---|---|---|
| z.bolortsetseg@khurdan.gov.mn | "Төв Шуудан" дахь "ХУРДАН" цэг | Last-Kiosk Системээр тоон гарын үсэг олгосон | 100 |
| z.bolortsetseg@khurdan.gov.mn | Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газ... | Last-Kiosk Системээр тоон гарын үсэг олгосон | 1 |
| z.bolortsetseg@khurdan.gov.mn | "Төв Шуудан" дахь "ХУРДАН" цэг | ДАН-тай холбоотой бүртгэл | 158 |
| sarnai@khurdan.gov.mn | П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар т... | ДАН нууц үг үүсгэх | 198 |
| sarnai@khurdan.gov.mn | П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар т... | ДАН бүртгэл үүсгэх | 120 |
| sarnai@khurdan.gov.mn | Улсын нэгдүгээр төв эмнэлэг дэх "ХУРДАН" цэг | ДАН бүртгэл үүсгэх | 1 |
| sarnai@khurdan.gov.mn | П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар т... | ДАН-тай холбоотой бүртгэл | 1 |
| sarnai@khurdan.gov.mn | П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар т... | Last-Kiosk Системээр тоон гарын үсэг олгосон | 62 |

**ЗУРАГ 9.4**

• Оператор нь operator.e-mongolia.mn системээр үйлчилгээ үзүүлэхээс гадна e-business.mn, e-mongolia.mn, аппликейшн ашиглаж иргэн, аж ахуй нэгжид үйлчилгээ үзүүлж, тоон гарын үсэг олгож, бусад нэмэлт за авар зөвлөгөө иргэнд өгдөг. Энэ цэсэд оператор бусад нэмэлт ажлаа бүртгэх цэс юм. Зураг 10.1

- **Бусад ажлын жагсаалт харах;**
- **Бусад ажлын жагсаалт татах;**
- **Хайлтын утга цэвэрлэх боломжтой.**




**ЗУРАГ 10.1** Бусад ажлын жагсаалт

• **Анхааруулга:** Үйлчилгээ үзүүлээд төлбөр төлсний дараа дэлгэц цагаарах, лавлагаа шууд үүсэхгүй алдаа үүссэн тохиолдолд оператор хэрэглэгч та operator.e-mongolia.mn системийнхээ Pop-ups and redirects-г Allow (defualt) болгоно уу.

## Алхам 1 View site information



## Алхам 2 Site settings - Privacy and security




## Алхам 3 Pop-ups and redirects – Allow / *defualt* /

